



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/111

Улаанбаатар хот

Албан хэрэг хөтлөлтийн "eDoc" систем ашиглах журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл, Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Цахим гарын үсгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1 дэх заалт, 41 дүгээр зүйлийн 41.6 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 246 дугаар, 2021 оны 226 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Албан хэрэг хөтлөлтийн "eDoc" систем ашиглах журмыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг нийслэлийн бүх шатны нутгийн захиргааны болон харьяа байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.
3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангахыг Нийслэлийн Архивын газар (Н.Туул)-т, системийн хэвийн үйл ажиллагаа, шаардлагатай хөгжүүлэлтийг тухай бүр хийж ажиллахыг нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар (О.Чинзориг)-т тус тус үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (И.Баатархүү)-т даалгасугай.
5. Энэ захирамж гарсантай холбогдуулан "Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам" батлах тухай Нийслэлийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/252 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР



111020000482

Нийслэлийн Засаг даргын 2023 оны
02 дугаар сарын 07-ний өдрийн
А/191 дугаар захирамжийн
хавсралт



АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН “eDoc” СИСТЕМ АШИГЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журам нь төрийн нууцын зэрэглэлд хамаарахаас бусад баримт бичгийг албан хэрэг хөтлөлтийн “eDoc” системээр зохион бүрдүүлэх, хүлээн авах, бүртгэх, шилжүүлэх, тоон гарын үсгээр баталгаажуулан илгээх, солилцох, шийдвэрлэлтэд хяналт тавих, тайлагнах, ангилан төрөлжүүлэх, хэрэг бүрдүүлэх, хадгалах, ашиглах болон мэдээллийн систем хэрэглэгчдийн эрхийн түвшинг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Албан хэрэг хөтлөлтийн “eDoc” системийг ашиглах үйл ажиллагаанд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Монгол хэлний тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээллийн хамгаалах тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Баримт бичгийн стандарт (MNS5140-1:2021, MNS5140-2:2021, MNS5140-3:2021), Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам” болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.3.Нийслэлийн нутгийн захиргааны болон төсөвт, өмчит, өмчийн оролцоотой бүх шатны байгууллага, (цаашид “байгууллага” гэх)-ууд албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд “eDoc” системийг ашиглана.

1.4.Мэдээллийн систем нь <https://edoc.ulaanbaatar.mn/> домэйн нэртэй байна.

Хоёр.Нэр томьёо

2.1.Энэхүү журамд заасан нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1.“eDoc” систем гэж байгууллагуудын цахим албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хэрэглэх программ хангамжийг (цаашид “мэдээллийн систем” гэх);

2.1.2.“Системийн администратор” гэж байгууллага, албан тушаалтан, албан хаагчид мэдээллийн системд хандах эрх тохируулан олгох, засварлах, идэвхгүй болгох, бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавих, зөрчил тооцох эрхтэй хэрэглэгчийг;

2.1.3.“Системийн хэрэглэгч” гэж системд бүртгэлтэй, тодорхой эрхийн түвшинд хандах эрх олгогдсон албан хаагчийг;

2.1.4.“Системд хандах эрх” гэж хэрэглэгч мэдээллийн системд баримт бичиг боловсруулах, хянах, зөвшөөрөх, мэдээлэл оруулах, өөрчлөх, харах эрхийн хязгаарыг;

2.1.5.“Хяналтын ажилтан” гэж системийн администратораас эрх олгогдсон, байгууллагын мэдээллийн системд бүртгэгдсэн нийт бичгийн эргэлт, шийдвэрлэлтийн үйл ажиллагаанд нэгдсэн хяналт тавих, зөрчил бүртгэх, тооцох байгууллагын бичиг хэргийн ажилтныг;

2.1.6.“Цахим баримт бичиг” гэж Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д заасныг;

2.1.7.“Тоон гарын үсэг” гэж Цахим гарын үсгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасныг;

2.1.8.“Цахим гарын үсэг” гэж Цахим гарын үсгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10-т заасныг;

2.1.9. “Бүртгэл хяналтын карт” гэж байгууллагад цахим хэлбэрээр ирсэн бичгийг бүртгэлд авсан тухай мэдээлэл, удирдлагын цохолт, шийдвэрлэх хугацаа, шийдвэрлэсэн тухай тэмдэглэлийг агуулсан хүснэгтэн мэдээллийг; (Хавсралт 1)

2.1.10. “Цахим бүртгэлийн дугаар” гэж ирсэн болон явуулсан баримт бичгийг хүлээн авсан хэлбэрийг илэрхийлсэн мэдээллийн системээс өгөгдсөн дахин давтагдашгүй дор дурдсан тоон утгыг ойлгоно:

2.1.10.1. цахим бүртгэлийн “Т0000000000” дугаар гэж нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвөөс мэдээллийн системд бүртгэсэн баримт бичгийн тоон утгыг;

2.1.10.2. цахим бүртгэлийн “Ц0000000000” дугаар гэж мэдээллийн систем ашигладаг болон бусад систем ашигладаг байгууллагаас бүртгэсэн баримт бичгийн тоон утгыг;

2.1.10.3. цахим бүртгэлийн “Б0000000000” дугаар гэж байгууллагад ирсэн цаасан суурьт баримт бичгийг мэдээллийн системд бүртгэхэд өгөгдсөн тоон утгыг;

2.1.10.4. цахим бүртгэлийн “Я0000000000” дугаар гэж байгууллагаас явуулсан баримт бичигт мэдээллийн системээс өгөгдсөн тоон утгыг.

Гурав. Мэдээллийн систем дэх баримт бичгийн эргэлтийн зохион байгуулалт

3.1. Ирсэн баримт бичгийг дараах эх үүсвэрээр цаасан болон цахим хэлбэрээр хүлээн авна:

3.1.1. албан хэрэг хөтлөлтийн “eDoc” систем;

3.1.2. албан хэрэг хөтлөлтийн бусад систем;

3.1.3. нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв;

3.1.4. байгууллагад.

3.2. Мэдээллийн систем ашигладаггүй төрийн байгууллага, хүн, хуулийн этгээд, байнгын бус ажиллагаатай ажлын хэсэг, зөвлөл, хороо, комисс болон олон улсын байгууллагаас цаасан хэлбэрээр ирүүлсэн баримт бичгийг Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв болон тухайн байгууллагад хүлээн авна.

3.3. Бичиг хэргийн ажилтан мэдээллийн системээр ирсэн цахим баримт бичгийг хүлээн авахдаа байгууллагын хаяг, албан тушаалтны нэр, он, сар, өдрийг бүрэн, зөв бичсэн бүрдэл бүрэн эсэхийг шалгаж хүлээн авна.

3.4. Мэдээллийн системээр ирсэн цахим баримт бичгийг дор дурдсан үндэслэлээр буцаана:

3.4.1. ирсэн баримт бичигт хүлээн авах байгууллагын нэр болон албан тушаалтны нэрийг буруу бичсэн, байгууллага андуурч илгээсэн, албан бичгийн цахим хувь, хавсралт дутуу, баримт хавсаргаагүй тохиолдолд ирсэн даруйд нь;

3.4.2. ирсэн баримт бичгийн шийдвэрлэх хугацаа мэдээллийн системд зөрүүтэй бүртгэгдсэн, шийдвэрлэх хугацаа дууссан баримт бичгийг ирсэн даруйд нь;

3.4.3. тухайн байгууллагын эрхлэх асуудал болон үндсэн үйл ажиллагаа, чиг үүрэгтэй хамааралгүй тохиолдолд ирсэн даруйд нь.

3.5. Байгууллагын бичиг хэргийн ажилтан энэ журмын 3.4-т заасан баримт бичгийг буцаахдаа мэдээллийн системд тэмдэглэл хөтлөн, илгээсэн байгууллагад мэдэгдэж буцаана.

3.6. Бичиг хэргийн ажилтан мэдээллийн системээр буцаагдсан баримт бичгийн тэмдэглэлтэй танилцаж, үндэслэлтэй гэж үзвэл тухайн зөрчил гаргасан ажилтанд зөрчил тооцон хүлээн авна. Хэрэв буцаасан тэмдэглэл үндэслэлгүй бол татгалзана.

3.7. Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв болон байгууллагад цаасан хэлбэрээр ирсэн баримт бичигт байгууллага, албан тушаалтны нэр буруу бичсэн, андуурч ирсэн, гарын үсэг, тамга, тэмдэг, хавсралт, бүрдэл дутуу бол хүлээн авахгүй.

3.8. Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв болон байгууллагад цаасан хэлбэрээр ирсэн баримт бичгийг мэдээллийн системд бүртгэхдээ дараах мэдээллийг оруулна:

- 3.8.1. хаанаас (Байгууллагын нэр);
- 3.8.2. хэнээс (Удирдлагын нэр);
- 3.8.3. бичгийн дугаар;
- 3.8.4. бичгийн он, сар, өдөр;
- 3.8.5. хариутай эсэх;
- 3.8.6. дээд газраас ирсэн эсэх;
- 3.8.7. шийдвэрлэх он, сар, өдөр;
- 3.8.8. хуудасны тоо;
- 3.8.9. товч утга;
- 3.8.10. хавсралттай эсэх.

3.9. Цаасан хэлбэрээр ирсэн баримт бичгийг мэдээллийн системд бүртгэхдээ шийдвэрлэх хугацааг энэ журмын 3.12.1-3.12.5-д заасныг үндэслэнэ.

3.10. Дараах тохиолдолд баримт бичгийг мэдээллийн системд бүртгэхгүй:

3.10.1. төрийн нууцын зэрэглэлд хамаарах баримт бичиг байгууллагад ирсэн тохиолдолд мэдээллийн системд бүртгэхгүй;

3.10.2. мэдээллийн системээр ирсэн баримт бичиг байгууллагад цаасан хэлбэрээр ирсэн тохиолдолд давхар бүртгэхгүй.

3.11. Ирсэн баримт бичгийг удирдлага, нэгжийн удирдлага, холбогдох ажилтанд шилжүүлнэ:

3.11.1. бичиг хэргийн ажилтан мэдээллийн системд бүртгэсэн баримт бичгийг өдөрт нь багтаан холбогдох байгууллага, удирдлагад шилжүүлнэ;

3.11.2. байгууллага, нэгжийн удирдлага мэдээллийн системээр ирсэн баримт бичигтэй танилцаж тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэх, хариуцах, эсхүл хамтран шийдвэрлэх албан хаагч, шийдвэрлэж танилцуулах хугацаа, хариу өгөх хэлбэрийг зааж холбогдох албан хаагчид өдөрт нь шилжүүлнэ;

3.11.3. байгууллага, нэгжийн удирдлага мэдээллийн системээр ирсэн баримт бичгийг албан хаагчид андуурч шилжүүлсэн тохиолдолд албан хаагч шилжүүлсэн удирдлагад мэдэгдэн өдөрт нь буцаана;

3.11.4. дээд шатны байгууллага, албан тушаалтнаас "Хариуг түүгээр хүргүүлэх" цохолттой ирсэн баримт бичгийг эцэслэн шийдвэрлэсэн байгууллага нь холбогдох байгууллага, нэгж, иргэнд хариуг хүргүүлж, цохолт хийсэн байгууллага, удирдлагад мэдэгдэнэ.

3.12. Баримт бичгийг дор дурдсан хугацаанд шийдвэрлэнэ:

3.12.1. шууд болон яаралтай шийдвэрлэх баримт бичгийг ажлын 1-3 хоногт;

3.12.2. ерөнхий хугацаагаар шийдвэрлэх баримт бичгийг удирдлага цохолт хийсэн өдрөөс эхлэн ажлын 7 хоногт;

3.12.3. нэмэлт баримт, мэдээлэл бүрдүүлэх, судлах, тооцоолол хийх өөр байгууллага, албан тушаалтнаас тодруулга, лавлагаа авч, бусад байгууллагатай хамтран судалж шийдвэрлэх хариутай бичгийг хуанлийн 30 хоногт;

3.12.4. шийдвэрлэх хугацааг баримт бичигт заасан бол дурдсан хугацаанд;

3.12.5. хуулийн этгээдээс тодорхой үйл ажиллагааг эрхлүүлэх, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглах тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтээ албан бичгээр ирүүлсэн тохиолдолд Зөвшөөрлийн тухай хуульд заасан хугацаанд.

3.13. Баримт бичгийн шийдвэрлэх хугацааг зайлшгүй шалтгаанаар өөрчлөх буюу сунгах хүсэлтийг албан хаагч мэдээллийн системээр бичиг шилжүүлсэн удирдах албан

тушаалтанд илгээнэ. Удирдлага ирсэн хүсэлттэй өдөрт нь танилцаж, хуанлийн 30 хүртэл хоногоор 1 удаа сунгаж болно.

3.14. Албан хаагч баримт бичгийн шийдвэрлэх хугацааг сунгахдаа бичгийн шийдвэрлэх хугацаа дуусахаас 3 хоногийн өмнө ирүүлсэн байгууллагад заавал мэдэгдэнэ.

3.15. Тусгай болон энгийн зөвшөөрөл олгохтой холбоотой төрийн болон мэргэжлийн байгууллагаас дүгнэлт, тодорхойлолт гаргуулах шаардлагатай бол Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасан хугацааг 1 удаа ажлын 5 өдрөөр сунгаж болно.

3.16. Ирсэн баримт бичгийг дор дурдсанаар шийдвэрлэнэ:

3.16.1. шийдвэрлэх шатанд байгаа баримт бичгийн шийдвэрлэлтийн явцын талаарх тэмдэглэлийг хариуцсан албан хаагч мэдээллийн системд ажлын 10 хоног тутам хөтөлнө;

3.16.2. байгууллагын удирдлагаас эргэн танилцуулах цохолттой ирсэн баримт бичигт албан хаагч заасан хугацаанд мэдээллийн системд тэмдэглэл хөтөлнө;

3.16.3. албан хаагч ирсэн баримт бичгийг бүрэн шийдвэрлэж дууссаны дараа мэдээллийн системийн шийдвэрлэх хэсэгт шийдвэрлэлтийн тухай дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлнө.

3.17. Баримт бичгийн шийдвэрлэлтэд дор дурдсан албан хаагч хяналт тавина:

3.17.1. байгууллагын хэмжээнд ирсэн баримт бичгийн шийдвэрлэлтийн үйл ажиллагаанд бичиг хэргийн ажилтан;

3.17.2. нэгжийн хэмжээнд ирсэн баримт бичгийн шийдвэрлэлтийн үйл ажиллагаанд бүтцийн нэгжийн дарга.

3.18. Баримт бичгийн шийдвэрлэлийн мэдээг дор дурдсан хугацаанд гарган тайлагнана:

3.18.1. нийслэлийн Архивын газар нь мэдээллийн систем ашиглагч байгууллагын ирсэн, явуулсан баримт бичгийн шийдвэрлэлтэд нэгдсэн хяналт тавьж, шийдвэрлэлтийн мэдээ, тайланг сар, улирал, хагас жил, жилээр гарган дараа сарын 01-ний дотор нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох нэгжид тайлагнана:

3.18.1.1. нийслэлийн хэмжээнд ирсэн бичгийн шийдвэрлэлтийн мэдээ;

3.18.1.2. нийслэлийн хэмжээнд хугацаа хэтэрч хаагдсан бичгийн шийдвэрлэлтийн мэдээ;

3.18.1.3. нийслэлийн хэмжээнд хугацаа хэтэрсэн хаагдаагүй бичгийн мэдээ;

3.18.1.4. нийслэлийн хэмжээнд явуулсан бичгийн шийдвэрлэлтийн мэдээ;

3.18.1.5. нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн зөрчлийн мэдээ.

3.18.2. Байгууллагын бичиг хэргийн ажилтан мэдээллийн системээр дор дурдсан мэдээ тайланг сар, улирал, хагас жил, жилийн эцсээр гарган удирдлагад танилцуулна:

3.18.2.1. ирсэн бичгийн шийдвэрлэлтийн мэдээ (Хавсралт 2);

3.18.2.2. хугацаа хэтэрч хаагдсан хариутай бичгийн мэдээ (Хавсралт 3);

3.18.2.3. хугацаа хэтэрсэн хаагдаагүй бичгийн мэдээ (Хавсралт 4);

3.18.2.4. явуулсан бичгийн шийдвэрлэлтийн мэдээ (Хавсралт 5);

3.18.2.5. байгууллагын хэмжээнд бүртгэгдсэн зөрчлийн мэдээ (Хавсралт 6);

3.18.2.6. хяналтын тайлан (Хавсралт 7).

3.18.3. Дүүргийн Архивын тасаг харьяа байгууллагуудын мэдээллийн систем ашиглалт, ирсэн, явуулсан баримт бичгийн шийдвэрлэлтэд нэгдсэн хяналт тавьж, шийдвэрлэлтийн мэдээг энэ журмын 3.6.7.1-3.6.7.5-д заасны дагуу нэгтгэн, сар бүрийн мэдээг дараа сарын 01-ний дотор, хагас жил, жилийн эцсийн мэдээг сүүлийн сарын 10-ны дотор нийслэлийн Архивын газрын холбогдох хэлтэст тайлагнана.

3.19. Мэдээллийн системд баримт бичиг боловсруулахдаа:

3.19.1. хэвлэмэл хуудасны төрөл, тэргүү бүрдэл, агуулга, ирсэн бичгийн хариу бол бичгийн дугаар, хавсралттай эсэх мэдээллийг заавал оруулсан байна;

3.19.2.мэдээллийн системээр явуулах баримт бичгийн хавсралтыг өргөн хэрэглэгддэг файлын формат (.doc, .docx, .xls, .xlsx, .pdf, .rtf, зураг, аудио гэх мэт)-аар хавсаргана. Нэгээс дээш нэр төрлийн хавсралттай бол тус тусад нь хавсаргана;

3.19.3.мэдээллийн системээр явуулах баримт бичигт харилцагч байгууллагын албан ёсны нэрийг бүтнээр бичиж, нэрийн ард "Д", "Т" "НД", албан тушаалтанд илгээж байгаа бол "Танаа" гэсэн нөхцөлийг залгаж бичнэ;

3.19.4.ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг хэд хэдэн байгууллагад баримт бичиг явуулах бол мэдээллийн системд харилцагч байгууллагын нэрийг ерөнхий байдлаар бичнэ. (Жишээ нь: Дүүргүүдийн Засаг дарга нарт, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад гэх мэт);

3.19.5.бичиг хэргийн ажилтан мэдээллийн системээр явуулах баримт бичгийн боловсруулалт, стандартад хяналт тавьж, гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтны индексийг сонгон дугаар олгож илгээнэ;

3.19.6.байгууллагын удирдлага мэдээллийн системээр явуулах баримт бичгийг тоон гарын үсгээр баталгаажуулахдаа баримт бичгийн он, сар, өдрийг тухайн өдрөөр сонгоно;

3.19.7.албан бичиг, захидлыг монгол бичгээр зохион бүрдүүлж илгээхдээ "Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага MNS6395:2022" стандартыг мөрдөнө.

3.20.Мэдээллийн системээр явуулах баримт бичгийг дор дурдсан үндэслэлээр бүртгэж илгээнэ:

3.20.1.мэдээллийн систем ашигладаггүй төрийн захиргааны төв, байгууллага болон иргэн, хуулийн этгээдэд явуулах цаасан суурьтай баримт бичгийг мэдээллийн системд бүртгэхдээ дор дурдсан мэдээллийг заавал бүртгэнэ:

3.20.1.1.бичгийн дугаарын төрөл (нэгжийн индекс);

3.20.1.2.явуулах бичгийн дугаар;

3.20.1.3.явуулах бичгийн он, сар, өдөр;

3.20.1.4.хуудасны тоо;

3.20.1.5.хавсралттай эсэх;

3.20.1.6.товч утга;

3.20.1.7.хариутай эсэх;

3.20.1.8.шийдвэрлэх он, сар, өдөр;

3.20.1.9.хүлээн авах байгууллага;

3.20.1.10.бичгийн төрөл;

3.20.1.11.боловсруулсан ажилтны нэр;

3.20.1.12.хянасан ажилтны нэр;

3.20.1.13.гарын үсэг зурсан албан тушаалтны нэр.

3.20.2.мэдээллийн системээр явуулах баримт бичгийн шийдвэрлэх огноог бүртгэхдээ дор дурдсан хугацааг сонгоно:

3.20.2.1.явуулах баримт бичгийн хариу яаралтай бол шийдвэрлэх хугацааг ажлын 3 хоногоор;

3.20.2.2.шийдвэрлэх хугацааг заасан бол дурдсан хугацаагаар;

3.20.2.3.нэмэлт мэдээлэл бүрдүүлэх, өөр байгууллага, албан тушаалтнаас тодруулга авах, бусад байгууллагатай хамтран судалж, шийдвэрлэх бол хугацааг хуанлийн 30 хоногоор.

3.20.3.байгууллагын бичиг хэргийн ажилтан тоон гарын үсгээр баталгаажсан баримт бичгийг илгээхдээ шийдвэрлэх он, сар, өдөр, хуудасны тоо, хариутай эсэх мэдээллийг нягтлан шалгаж, зөрчилгүй бол өдөрт нь илгээнэ;

3.20.4.тоон гарын үсгээр баталгаажсан, явуулах цахим баримт бичгийг мэдээллийн систем ашигладаг байгууллагад шууд, ашигладаггүй төрийн захиргааны төв, байгууллага болон иргэн, хуулийн этгээдэд илгээхдээ хэвлэмэл хуудсанд буулган гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажсан цаасан суурьтай эх бичгийг илгээнэ;

3.20.5.цахим баримт бичгийг хүлээн авсан байгууллагаас хууль тогтоомжид заасны дагуу баримт нотолгоо, хавсралт бүрдүүлбэр шаардсан тохиолдолд цаасан суурьт эх баримт бичгийг шуудангаар явуулж болно;

3.20.6.мэдээллийн системээр баримт бичгийг илгээсэн даруйд, ажлын цаг дууссан үед, эсхүл амралтын өдөр шилжүүлсэн бол дараагийн ажлын өдөр хүлээн авсанд тооцно;

3.20.7.мэдээллийн системээр илгээсэн баримт бичгийг харилцагч байгууллага хүлээн авч, удирдах албан тушаалтан цохолт хийснээс хойш түүнийг илгээгч байгууллага цуцлахыг хориглоно.

3.21.Харилцсан баримт бичгээр дор дурдсанаар хэрэг бүрдүүлэн хадгална:

3.21.1.“Архивын баримтын нэр, төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт”, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасны дагуу цаасан болон цахим хэлбэрээр ирсэн түр хадгалах баримт бичгийг шийдвэрлэж дууссаны дараа бүртгэл хяналтын картын хамт ангилан төрөлжүүлж, зориулалтын хадгалах төхөөрөмж (storage), бүх төрлийн сервер, компьютер, хатуу диск зэрэг тоон технологийн шийдэл ашиглан 3-аас багагүй тээгч дээр, байнга хадгалах баримт бичгийг шийдвэрлэж дууссаны дараа бүртгэл хяналтын картын хамт цаасан суурьт буулган хэрэг бүрдүүлнэ;

3.21.2.явуулсан баримт бичгийн байгууллагад үлдэх хувийг “Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт”, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасны дагуу хэвлэмэл хуудсанд буулган байгууллагын даргын гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажуулан цаасан суурьт эх баримтаар хэрэг бүрдүүлнэ;

3.21.3.ирсэн бичгийн бүртгэл (Хавсралт-8), явуулсан бичгийн бүртгэл (Хавсралт-9)-ийг цаасан болон цахим хэлбэрээр хэрэг бүрдүүлэн хадгална.

3.22.Мэдээллийн систем дэх баримт бичигт дор дурдсан үндэслэлээр зөрчил тооцно:

3.22.1.мэдээллийн системээр баримт бичгийг илгээсэн болон хүлээн авсан байгууллагын удирдлага, нэгжийн удирдлага, албан хаагч, бичиг хэргийн ажилтанд дор дурдсан 4 чиглэлээр 34 төрлийн зөрчил тооцно:

3.22.1.1.стандартын зөрчил:

- а.байгууллагын нэр буруу бичсэн (01);
- б.тэргүү бүрдэл оновчтой бус (02);
- в.бичвэрийн утга, найруулга оновчтой бус (03);
- г.зөв бичгийн дүрмийн алдаатай (04);
- д.хавсралтын тухай мэдээлэл бүрэн бус тодорхойгүй (05);
- е.тамга, тэмдэг ашиглалт буруу (06);
- ж.гарын үсэг бүрдлийн алдаа (07);
- з.албан бичигт файлын нэр бичиж илгээсэн (08);
- к.хариутай бичгийн огноо, дугаарын тэмдэглэл бичээгүй (09);
- л.хандсан албан тушаалтны нэр, албан тушаалыг буруу бичсэн (10);
- м.хариутай бичгийг хариугүй төлөвтэй бүртгэсэн (11);
- н.тоон гарын үсгээр баталгаажуулаагүй (12).

3.22.1.2.систем ашиглалтын зөрчил:

- а.байгууллагын нэр андуурч илгээсэн (13);
- б.цахим баримт бичгийг байгууллагын удирдлагад шилжүүлээгүй (14);
- в.удирдлага цахим баримт бичигтэй танилцаж, удирдлагын заалт тэмдэглээгүй (15);
- г.цахим баримт бичгийг байгууллагын нэгжийн удирдлагад шилжүүлээгүй (16);

- д.цахим баримт бичгийг шийдвэрлэх ажилтанд шилжүүлээгүй (17);
- е.хавсралтын цахим хувийг буруу хавсаргасан болон хавсаргаагүй (18);
- ж.албан бичгийн огноо, дугаар программын бүртгэлтэй зөрсөн (19);
- з.албан бичгийн шийдвэрлэлтийн хугацааг программд буруу оруулсан (20);
- к.албан бичгийн хаагдах хэлбэрийг буруу цохсон (21);
- л.хугацаа хоцроож системд бүртгэж, илгээсэн (22);

- м.системд бүртгэгдсэн бичгийг дахин бүртгэж илгээсэн (23);
- н.албан бичгийн эх хувийг хавсаргаагүй (24);
- р.байгууллага хооронд шилжин ирэхдээ шийдвэрлэх хугацаа дууссан (25);
- с.ирсэн бичигт хянан шийдвэрлэх боломжит хугацаа өгөөгүй (26);
- т.бичиг устгуулсан (27).

3.22.1.3.шийдвэрлэх хугацааны зөрчил:

- а.ирсэн бичгийг өдөрт нь шилжүүлээгүй (28);
- б.хариутай бичгийн хариуг хугацаанд нь ирүүлээгүй (29);
- в.ирсэн бичгийг хугацаанд нь шийдвэрлээгүй (30).

3.22.1.4.бичгийн шийдвэрлэлтийн зөрчил:

- а.хариугүй бичигт тэмдэглэл үйлдэж хаагаагүй (31);
- б.монгол хэлний дүрмийн алдаатай, үсгийн тэмдэгт танигдаагүй (32);
- в.явцын тэмдэглэл хөтлөөгүй (33);
- г.баримт бичгийн шийдвэрлэлт тодорхой бус оновчгүй (34).

3.22.2.Мэдээллийн систем хэрэглэгч байгууллагын удирдлага, нэгжийн удирдлага энэ журмын 3.22.1.1-ийн “н”, 3.22.1.2-ын “в”, “г”, “д”, “ж”, “к”, “р”, 3.22.1.3-ын “а”-д заасан, албан хаагч энэ журмын 3.22.1.1-ын “а”, “б”, “в”, “г”, “д”, “з”, “к”, “л”, 3.22.1.2-ын “е”, 3.22.1.3-ын “б”, “в”, 3.22.1.4-ийн “а”, “б”, “в”, “г”-д заасан, бичиг хэргийн ажилтан энэ журмын 3.22.1.1-ын “м”, 3.22.1.2-ын “а”, “б”, “з”, “л”, “м”, “н”, “с”, “т”-д заасан зөрчлийг тус тус гаргасан тохиолдолд мэдээллийн систем автоматаар, хяналтын эрхтэй албан хаагчид хяналтын явцад зөрчил тооцно.

3.22.3.Зөрчил тооцох албан тушаалтнуудыг мэдээллийн системд дараах байдлаар томъёолно:

3.22.3.1.илгээсэн байгууллагын удирдлага, нэгжийн удирдлага, албан хаагч, бичиг хэргийн ажилтан;

3.22.3.2.хүлээн авсан байгууллагын удирдлага, нэгжийн удирдлага, албан хаагч, бичиг хэргийн ажилтан.

3.22.4.Албан хаагчдаас мэдээллийн системд зөрчил тооцуулахаар ирүүлсэн саналыг системийн администратор болон дүүргийн архивын тасгийн хяналтын ажилтан нягтлан шалгаж, зөрчлийг баталгаажуулна.

3.22.5.Нийслэлийн байгууллагуудын баримт бичгийн шийдвэрлэлт, үйл ажиллагааны индекс мэдээллийн системд автоматаар дор дурдсан утгаар тооцно: (Хавсралт 10)

- 3.22.5.1.албан бичгийн хандалтын индекс;
- 3.22.5.2.албан бичгийн шийдвэрлэлтийн индекс;
- 3.22.5.3.албан бичгийн шийдвэрлэлтийн хугацааны индекс;
- 3.22.5.4.албан бичгийн шийдвэрлэлтийн зөрчлийн индекс.

3.22.6.Мэдээллийн системд албан бичгийн шийдвэрлэлт, үйл ажиллагааны индексийн үнэлгээг дараах байдлаар нэгтгэн үнэлнэ:

- 3.22.6.1.албан бичгийн индекс 0.849 – 0.999 бол “А” үнэлгээ;
- 3.22.6.2.албан бичгийн индекс 0.699 – 0.848 бол “В” үнэлгээ;
- 3.22.6.3.албан бичгийн индекс 0.549 – 0.698 бол “С” үнэлгээ;
- 3.22.6.4.албан бичгийн индекс 0.399 – 0.548 бол “D” үнэлгээ;
- 3.22.6.5.албан бичгийн индекс 0.001 – 0.398 бол “F” үнэлгээ.

Дөрөв.Мэдээллийн систем хэрэглэгчийн хүлээх үүрэг

4.1.Нийслэлийн Засаг даргын Тамгын газар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1.нийслэлийн хэмжээнд мэдээллийн систем ашиглалтыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавих;

4.1.2.нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын баримт бичгийн боловсруулалт, шийдвэрлэлтэд хяналт тавих;

4.1.3.мэдээллийн системд шаардлагатай хөгжүүлэлтийг хийх, холбогдох зардлыг шийдвэрлэх.

4.2. Нийслэлийн Архивын газар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.2.1. нийслэлийн хэмжээнд мэдээллийн систем ашиглалтын өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах, зааварчилгаа өгөх, хяналт тавих;

4.2.2. мэдээллийн систем хэрэглэгч байгууллага, албан тушаалтан, албан хаагчийн эрхийн тохиргоог хийх, засварлах, идэвхгүй болгох;

4.2.3. мэдээллийн системд бүртгэлгүй төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдийн бүртгэлийг шинээр бүртгэх;

4.2.4. мэдээллийн системээр нийслэлийн хэмжээнд ирсэн баримт бичгийн эргэлт, шийдвэрлэлт, боловсруулалт, зөрчил тооцох, цуцлах, засварлах, санал шийдвэрлэх, хугацаа сунгах үйл ажиллагаанд хяналт тавих;

4.2.5. нийслэлийн Архивын газар нь нийслэлийн хэмжээнд цахим албан хэрэг хөтлөлт, мэдээллийн систем ашиглах үйл ажиллагаанд гарч буй зөрчил, дутагдлыг арилгуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх.

4.3. Салбар архив, болон дүүргийн Архив дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.3.1. дүүргийн харьяа байгууллагуудын мэдээллийн систем ашиглалтыг сайжруулах, өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах, зааварчилгаа өгөх, хяналт тавих;

4.3.2. мэдээллийн системд бүртгэлгүй төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдийн бүртгэлийг шинээр бүртгэх;

4.3.3. дүүргийн харьяа байгууллагуудын хэмжээнд ирсэн баримт бичгийн эргэлт, шийдвэрлэлт, боловсруулалт, зөрчил тооцох, санал шийдвэрлэх, хугацаа сунгах үйл ажиллагаанд хяналт тавих.

4.4. Байгууллага болон нэгжийн удирдлага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.4.1. байгууллагын удирдлага нь байгууллагын хэмжээнд ирсэн бүх бичгийг харах, ирсэн бичгийг холбогдох нэгжийн удирдлага, ажилтанд шилжүүлэх, баримт бичиг боловсруулалт, илгээлт, ирсэн, явуулсан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавих;

4.4.2. баримт бичгийг зохион бүрдүүлэх, шилжүүлэх, ангилан төрөлжүүлж албан хэрэг бүрдүүлэх, цахим хэлбэрт шилжүүлэн мэдээллийн сан үүсгэх, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хавтас, файл үүсгэн хадгалах, тэдгээрийг байгууллагын архивт шилжүүлэхэд бэлтгэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;

4.4.3. албан хаагчдыг мэдээллийн системд аюулгүй, тасралтгүй, найдвартай ажиллах нөхцөлөөр хангана;

4.4.4. нэгжийн удирдлага нь нэгжийн хэмжээнд ирсэн бүх бичгийг харах, ирсэн бичгийг холбогдох ажилтанд шилжүүлэх, баримт бичиг боловсруулалт, стандарт, найруулга зүй, зөв бичгийн дүрэм, ирсэн, явуулсан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавих;

4.4.5. нэгжийн хэмжээнд баримт бичгийг зохион бүрдүүлэх, шилжүүлэх, ангилан төрөлжүүлж албан хэрэг бүрдүүлэх, цахим хэлбэрт шилжүүлэн мэдээллийн сан үүсгэх, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хавтас, файл үүсгэн хадгалах, тэдгээрийг байгууллагын архивт шилжүүлэхэд бэлтгэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;

4.4.6. хариуцсан нэгжийн албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны явцад үүсэж хөтлөгдсөн баримт бичгээс хуулбар хувь авах тохиолдолд тухайн баримт бичгийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг хариуцаж, "Хуулбар үнэн" тэмдэглэлд гарын үсэг зурж баталгаажуулна;

4.4.7. Байгууллага болон нэгжийн удирдлага нь эзэмшиж буй тоон гарын үсгийн төхөөрөмж (токен)-ийн аюулгүй байдал, нууцлал, ашиглалтыг бүрэн хариуцаж, ашиглаж дууссаны дараа төхөөрөмжийг компьютероос салган цоожтой шүүгээ, саванд хадгална;

4.4.8. Байгууллага болон нэгжийн удирдлага албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын 8 дугаар бүлгийн 8.1-д заасан хориглох зүйлийг мөрдөнө.

4.5. Албан хаагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.5.1.байгууллагын хүний нөөцийн админ эрхтэй ажилтан нь нийслэлийн дотоод удирдлагын (erp.ulaanbaatar.mn) системээр дамжуулан мэдээллийн системд ажиллах албан хаагчдын хэрэглэгчийн эрхийг холбох, нэгж, албан тушаалын эрэмбийн дагуу үүсгэх, эрхийг олгох, засварлах, идэвхгүй болгох;

4.5.2.албан хаагч мэдээллийн системээр баримт бичиг боловсруулахдаа Монгол хэлний зөв бичих дүрэм, стандартад заасан шаардлагын дагуу зохион бүрдүүлэх;

4.5.3.албан хаагч мэдээллийн системээр зөвхөн өөрт ирсэн баримт бичгийг харах бөгөөд баримт бичигт заасан асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд шийдвэрлэж тайлагнах;

4.5.4.албан хаагч 15 ба түүнээс дээш хоногийн хугацаагаар ажлаас түр чөлөөлөгдөх, ээлжийн амралт авах, өвдсөн тохиолдолд мэдээллийн системд ирсэн баримт бичгийг шийдвэрлэж хаасан байх, эсхүл нэгжийн удирдлагад хүлээлгэн өгч шийдвэрлүүлэх;

4.5.5.албан хаагч шилжсэн, сэлгэн ажилласан, ажлаас чөлөөлөгдсөн, халагдсан тохиолдолд мэдээллийн системд ирсэн баримт бичгийг заавал шийдвэрлэнэ;

4.5.6.албан хаагч албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

4.5.6.1.бичиг хэрэгт бүртгэгдээгүй баримт бичгийг хүлээн авч, шийдвэрлэх;

4.5.6.2.уншиж нийлээгүй, стандартын шаардлага хангаагүй, холбогдох бүтцийн нэгжийн даргаар хянуулаагүй, зохих журмын дагуу санал, зөвшөөрөл аваагүй баримт бичгийг байгууллагын удирдлагад танилцуулах;

4.5.6.3.албан хэрэг хөтлөлтийн явцад үүсэж хөтлөгдсөн мэдээллийн сан, баазаа устгах;

4.5.6.4.албан хэрэг хөтлөлтийн явцад олж авсан албаны мэдээллийн эх сурвалжийг бусдад тараах, мэдээлэх.

4.6.Бичиг хэргийн ажилтан дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.6.1.байгууллагын хэмжээнд мэдээллийн систем ашиглалтын талаар албан хаагчдыг арга зүйгээр хангах, заавар, зөвлөгөө өгөх;

